



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/226

Мандалговь

“Хос соёмбот өргөө” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/55 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сан, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Өвс, тэжээлийн агуулах саравч шинээр барих” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Хос соёмбот өргөө” ХХК-тай 198,651,889 (нэг зуун ерэн найман сая зургаан зуун тавин нэгэн мянга найман зуун наян ес) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу Өвс, тэжээлийн агуулах саравч шинээр барих ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Хос соёмбот өргөө” ХХК-ний захирал (С.Батсуурь)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210525